

Эрх Тодорхойлох Уулзалт: Гэр бүл/Асран Хамгаалагчдын Мэдлэгт

Сурагчийн Нэр:

Огноо:

Эрх Тодорхойлох Хороо гэж юу вэ?

Эрх Тодорхойлох Хороо нь таны хүүхэд сургуульд суралцахад нь дэмжлэг үзүүлэх тусгай боловсрол, холбогдох үйлчилгээ шаардахуйц хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлохоор байгуулагдсан баг юм.

Эрх Тодорхойлох Хороонд хэн багтах вэ?

Энэ багт сургуулийн ажилтнууд болон эцэг эх, асран хамгаалагч аль аль нь багтана. Гишүүд нь ихэвчлэн:

- Та (эцэг эх, асран хамгаалагч)
- Сургуулийн захиргааны ажилтан (захирал эсвэл захирлын туслах гэх мэт) - ихэвчлэн "LEA" (орон нутгийн боловсролын агентлагийн төлөөлөгч) гэж нэрлэдэг.
- Ерөнхий эрдмийн багш (таны хүүхдийн ангийн багш) Тусгай боловсролын багш
- Сурагч дэмжих Зохицуулагч (SSC) Сургуулийн сувилагч
- Сургуулийн сэтгэл зүйч Сургуулийн нийгмийн ажилтан
- Холбогдох үйлчилгээ үзүүлэгчид (хэл ярианы эмч, хөдөлмөр засалч гэх мэт) Таны эсвэл сургуулиас урьсан бусад хүмүүс

Уулзалтаар юу хэлэлцдэг вэ?

- Баг өөр өөр эх сурвалжаас авсан мэдээллийг авч үзэх болно, үүнд таны байр суурь, багшийн санал хүсэлт, ажиглалт, хийсэн аливаа шалгалт, үнэлгээ зэрэг орно.
- Танай хүүхдэд эрх тодорхойлох уулзалтад зориулж үнэлгээг хийсэн хүн бүр дүгнэлтээ хянаж, нэгтгэн дүгнэнэ.

Таны хүүхэд тусгай боловсрол, холбогдох үйлчилгээ шаардлагатай "хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд"-ийн шалгуурт тэнцэх эсэх талаар багийнхан хамтдаа ярилцана.

Ямар шийдвэрүүд гарах вэ?

- Баг Эрх тодорхойлох хуудас ашиглан нэг буюу хэд хэдэн хөгжлийн бэрхшээл байгаа эсэх, /хөгжлийн бэрхшээлийн шинж чанарыг тодорхойлдог. Авагдсан өгөгдөлд хэрэв хөгжлийн бэрхшээлтэй байгааг харуулсан нөхцөлд таны хүүхдэд эрх үүсэж буй эсэхийг тодорхойлохын тулд таны зөвшөөрлийг хүсэх болно.
- Баг нь зохих эрхийг тодорхойлохдоо талууд санал нийлэхүйц зөвшилцөх зарчмыг баримтална. Багийн гишүүн бүр шийдвэртэй санал нийлж буй эсэхээ илэрхийлэх боломжтой.



Энд уншуулж
Эрх тодорхойлох
хуудастай
танилцана уу

Эцэг эх/ Асран хамгаалагчийн зүгээс Эрх Тодорхойлох Уулзалтад ямар үүрэгтэй вэ?

- Уулзалтын үед яриа хэлэлцүүлэгт идэвхтэй оролцох. Жич: Хэрэв танд хэлмэрч ба/эсвэл уулзалтад оролцоход ADA хөнгөлөлт шаардлагатай бол энэ тухайгаа сургуульдаа мэдэгдэнэ үү.
- Өөрийн санаа, бодол, санаа зовоосон асуудлуудаа чөлөөтэй хуваалцаж болно.
- Шаардлагатай бол асуулт асууж, тодруулга аваарай.
- Эрх тодорхойлсон шийдвэртэй танилцаж, үүнийг зөвшөөрч буй эсэхээ илэрхийлнэ.
- Хэрэв танд хурлын үр дүнгээс эргэлзээтэй асуудал байгаа бол дараагийн алхмуудын талаар, тухайлбал маргаан шийдвэрлэх арга замуудын тухай асууж болно. Та мөн PRC-тай холбогдож нэмэлт мэдээлэл авах боломжтой.

Эрх Тодорхойлох Уулзалтад Бэлдэх



Уулзалтад бэлтгэлтэй, өөртөө итгэлтэй очих зарим зөвлөмж:

- ☒ Эцэг эхийн ярих тайлбарыг бичгээр гаргаж багийн гишүүдэд хурлаас өмнө илгээж танилцуулах. (Эцэг Эхчүүдийн Мэдээллийн Төв (PRC) -д эцэг эхийн тайлбар гаргах жишээ байгаатай танилцаж болно.)
- ☒ Хуваалцахыг хүссэн хувийн тайлангаа (жишээ нь, үнэлгээ, эрүүл мэндийн тайлан) эмхэтгэж, хурлаас өмнө урьдчилан илгээнэ үү.
- ☒ Багаас харгалзан үзэж буй хөгжлийн бэрхшээлийн ангилалд хамаарах эрх тодорхойлох жагсаалтай танилцах
- ☒ Үнэлгээний үр дүн бүхий эрх тодорхойлох ажлын багцтай эрх тодорхойлох хурал болохоос наад зах нь хоёр хоногийн өмнө авч танилцах боломжтой.
Хурал болохоос наад зах нь хоёр долоо хоногийн өмнө сургуулийнхаа тусгай боловсролын захиргааны туслахтай багцыг хүлээн авах төлөвлөгөөгөө баталгаажуулна уу. "Child Find" хөтөлбөрт үнэлгээ хийгдэж буй хүүхэдтэй гэр бүлүүд "Child Find" төвийн 703.228.2700 утсаар холбогдоно уу.
- ☒ Үнэлгээний үр дүнгүүдийг багтаасан эрх тодорхойлох багцыг сайтар хянаж үзэх цаг төлөвлөж зарцуулах.
- ☒ Хуваалцахыг хүссэн сэтгэгдэл/тэмдэглэлээ дараах "Ярилцах Сэдэв" хэсэгт бичиж тэмдэглэнэ үү.
- ☒ Уулзалтын үеэр асуухыг хүссэн асуултуудаа дараах "Асуулт" хэсэгт жагсааж бичнэ үү.
- ☒ Тусгай боловсролын үйл явцын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Эцэг Эхчүүдийн Мэдээллийн Төв (PRC)-с авна уу.
Хэрвээ боломжтой бол тус байгууллагаас явуулдаг "Тусгай Боловсрол ба Сурагч Дэмжих Процессын Танилцуулга" уулзалтад суух эсвэл яг одоо онлайнгаар үзээрэй! Энэ нь хэрэгтэй мэдээллээ олох шилдэг арга юм.
- ☒ Хэрэв та уулзалтад хэн нэгнийг (найз, өмгөөлөгч, гэр бүл гэх мэт) оролцуулахаар төлөвлөж байгаа бол энэ тухайгаа сургуульдаа урьдчилан мэдэгдсэнээр нэмэлт зай, материал бэлтгэх боломжтой юм.



PRC онлайн
Видео Хичээлүүд
WATCH NOW

Асуух Асуултууд	Ярилцах Сэдэв /Нэмэлт Асуулт
- Дараагийн алхмууд юу байх вэ? - Хэрэв манай хүүхдэд эрх үүссэн бол бидний Ганцаарчилсан Боловсролын Хөтөлбөр (IEP)-г хариуцаж мэдээлэл өгөх хүн хэн байх вэ? - Уулзалтаас гарсан шийдвэртэй холбоотой баримт бичгийг би хэзээ хүлээж авах вэ? - Өнөөдрийн уулзалтын үр дүнд санал нийлэхгүй бол би юу хийх вэ? - Хүүхэд эрх хангаж буй шийдвэрийг зөвшөөрөх эсэхийг шийдэхэд нэмэлт хугацаа хэрэгтэй байгаа үед яах вэ?	

ДЭЛГЭРЭНГҮЙ

PRC танд туслахад бэлэн байна.
Бидэнтэй 703.228.7239 утсаар
эсвэл prc@apsva.us хаягаар
холбогдоно уу.



PEATC: Эцэг
Эхийн Чухал
Эрхүүд



VDOE:
Эрх Тодорхойлох
тухай Видео



PEATC:
Үнэлгээний Тухай
Ойлголт



PEATC: Bell Curve
&
Стандартчилсан
тест



PEATC: Эрх
Тодорхойлох
Ажлын Жагсаалт



VDOE: Гэр
Бүлүүдийн Тусгай
Боловсролын
Гарын Авлага